

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр: ОНХС-ийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн  
Байгууллагын нэр: Бүрд сум

Аудитын код: ӨВА-2022/30-ШТ.

№	Аудитын чиглэл/асуулт	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагаас гаргасан шийдэл	Гаргасан шийдвэр	Биелэлт/тайлбар
1	1.1.4.Аймаг, нийслэл,сүм, дүүргийн ОНХС-д хуулиар олгогдох эх үүсвэрийн боломжийг судалж, орон нутгийн хөгжлийн санд нэмж төлөвлөж байна үү?	Бүрд сум Малын тоо толгойн албан татварын 35.7 сая төгрөгийг хуулийн хугацаанд нь төвлөрүүлээгүй байна.	35.7	Төлбөрийн акт	Хүлээн зөвшөөрсөн	Төлбөрийн акт	Манай сум 2021 онд Малын тоо толгойн албан татварт 98.4 сая төгрөгийг сумын төсөвт төвлөрүүлэхээс 62.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 63.7% биелэлттэй ажилласан. 2022 онд нөхөж төвлөрүүлэх тал дээр холбогдох албан тушаалтнууд ажиллаж 6.48 сая төгрөг төвлөрүүлсэн. Эдийн засгийн хямрал болон иргэдийн өрхийн орлогоос хамаарч татвар төлөхөд хүндрэлтэй байна. Цаашид оны эцсийн мал тооллогоор 100% нөхөж төлүүлэх тал дээр онцгой анхаарч ажиллах болно.
2	1.2.1. Шат, шатны төсвийн захирагчид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар авч эрэмбэлсэн үү?	Бүрд суманд иргэдийн санал аваагүй спорт заал, залуучуудын хөгжлийн төвийн дулааны шугамын засвар 20 сая төгрөг, хүүхдийн тоглоомын талбай 20.0 сая төгрөг, ЕБС-ийн биеийн тамирын зааланд бөхийн дэвжээнд 3.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй арга хэмжээг баталж санхүүжүүлсэн.	43.4	Албан шаардлага	Хүлээн зөвшөөрсөн	Албан шаардлага	ОНХС-ийн журмын 4.1.1 дэх заалт болон Сумын Засаг Даргын үйл ажиллагааны хөтөлбөр хүрээнд дээрх 3 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн. • СЗДаргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.2 дэх "Залуучуудын хөгжлийн төвийг түшиглэн спорт заал, фитнес клубийн үйл ажиллагааг тогтмолжуулна." гэсэн заалтын хүрээнд байнгын үйл ажиллагаа явуулахын тулд шугамын засвар хийгдсэн. • СЗДаргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.10 дэх "Хүүхдийн тоглоомын талбай байгуулна." гэсэн заалтын хүрээнд хийгдсэн ажил юм. • СЗДаргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.1 дэх "ЕБС-ийн спорт тоглоом тоног төхөөрөмжүүдийг шинэчилнэ." гэсэн заалтын хүрээнд ЕБС-ийн биеийн тамирын зааланд бөхийн дэвжээ авсан. Цаашид иргэдийн санал аваагүй СЗДаргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй төсөл арга хэмжээг санхүүжүүлэхгүй байхад анхаарч ажиллаж байна.
3	1.2.1. Шат, шатны төсвийн захирагчид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар авч эрэмбэлсэн үү?	Баг бүрээс санал авдаг боловч сумын төвийн багийн хүн ам бусад багуудаас их, мөн санал асуулгын хуудаст "Сум/дүүргийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан сум/дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр дараах байршилд .....онд хийгдэх ажлыг дэмжиж байгаа эсэх" гэсэн хэсэгт түлхүү сумын төвд хийгдэх боломжтой ажлуудыг төвийн, алслагдсан бүх багийн саналын хуудсанд тусгаж өгсөн, түс хэсэгт төсөл, арга хэмжээний жагсаалтуудыг бүрэн оруулж өгдөггүй байна.		Зөвлөмж	Хүлээн зөвшөөрсөн	Зөвлөмж	Цаашид журмын хэрэгжилтэд анхаарч баг бүрээс авсан саналууд дээр тулгуурлан төсөл, арга хэмжээний жагсаалтуудыг бүрэн оруулж өгч ажилласан.
4	1.2.1. Шат, шатны төсвийн захирагчид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар авч эрэмбэлсэн үү?	Сумдад анхан шатны санал хураалтын хүрээнд өрхүүдэд төдийлөн хангалттай саналын хуудаснуудыг хүргээгүй байна. Багуудын саналын хуудаснаас харахад зөвхөн нэг төвлөрсөн хэсгийн байруудыг хамруулсан, тэгш хүртээмжтэй байдлаар иргэдийн саналыг аваагүй байна.		Зөвлөмж	Хүлээн зөвшөөрсөн	Зөвлөмж	Цаашид журмын хэрэгжилтэд анхаарч санал асуулга авахдаа иргэдийг тэгш хүртээмжтэй оролцуулж, саналын хуудсыг хүртээмжтэй байдлаар тарааж иргэдийг идэвхжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажилласан.

5	1.2.1. Шат, шатны төсвийн захирагчид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар авч эрэмбэлсэн үү?	Сумын төвд БИНХ-ын ирц харилцан адилгүй зарим сумдад хүчин төгөлдөр ирц бүрдээгүй нөхцөлд хүрлэг зохион байгуулж иргэдийн саналыг эрэмбэлсэн байна.		Зөвлөмж	Хүлээн зөвшөөрсөн	Зөвлөмж	Цаашид алдаа дутагдал гаргахгүй, журмын хэрэгжилтийг хангаж багуудын хурлын ирц дээр анхаарч хурлыг зохион байгуулж иргэдийн саналыг эрэмбэлж ажилласан.
6	1.2.1. Шат, шатны төсвийн захирагчид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар авч эрэмбэлсэн үү?	Сумын Засаг дарга нь ИТХ-аар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажлын жагсаалтад иргэдийн өгсөн санал багтсан болон багтаагүй шалтгааныг бүрэн мэдээлээгүй байна.		Зөвлөмж	Хүлээн зөвшөөрсөн	Зөвлөмж	Сумын Засаг дарга нь ИТХ-аар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажлын жагсаалтад иргэдийн өгсөн санал багтсан болон багтаагүй шалтгааныг иргэдэд бүрэн мэдээлж ажилласан.
7	1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан үү?	Сумдад урьдчилсан жагсаалтыг бэлтгэхдээ жилийн хөгжлийн хөтөлбөр, урт хугацааны баримт бичгийн уялдааг бүрэн авч үздэггүй байна.		Зөвлөмж	Хүлээн зөвшөөрсөн	Зөвлөмж	Ажлын хэсэг, багийн засаг дарга нарт урт дунд богино хугацааны бодлогын бичгийн уялдааны талаар тухай бүрд нь мэдээлэл өгч, мэдлэгийг сайжруулах талаар арга хэмжээ авч ажилласан.
8	1.2.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-аас тухайн шатны Засаг даргын чиг үүрэгт хамаарах төсөл, арга хэмжээг тусгасан үү?	ОНХС-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу иргэдээс санал авсны дараа тус журмын 5 дугаар хэсэглэлийн дагуу багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх төслийн саналын урьдчилсан жагсаалт бэлтгэх бөгөөд тус жагсаалтыг бэлтгэхдээ ОНХС-аас санхүүжүүлэхийг хориглосон зүйлийг хүснэгтэд оруулахгүй гэж журамд заасан боловч зарим сумд урьдчилсан жагсаалтад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхийг хориглосон чиг үүргүүд бүхий ажлуудыг тусгажээ.		Зөвлөмж	Хүлээн зөвшөөрсөн	Зөвлөмж	Журмын хэрэгжилтэд анхаарч ажиллаж байна.
9	2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилготой түвшин, үр ашиг, үр дүнг бодитой тодорхойлсон үү?	Тухайн аймаг, суманд ямар асуудал шийдвэрлэх шаардлага үүссэн, түүнийг хэрхэн шийдвэрлэх тал дээр төлөвлөлтийн шатанд төдийлөн нарийн сайн төлөвлөлт хийгдээгүй төслийн зорилгыг хэт ерөнхий тодорхойлж байна.		Зөвлөмж	Хүлээн зөвшөөрсөн	Зөвлөмж	Төлөвлөлтийн шатанд сайн төлөвлөлт хийж төслийн зорилгыг нарийн тодорхойлж журмын хэрэгжилтийн хангаж ажилласан.
10	3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв бүртгэж тайлагнасан үү?	Бүрд сум ОНХС-ийн хөрөнгийг тайлагнахдаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх НББ-ийн дансны заавар"-ын 4.8-д заасны дагуу гэрээний үндсэн дээр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлын 18.4 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардлыг бүртгээгүй байна.	18.4	Зөвлөмж	Хүлээн зөвшөөрсөн	Зөвлөмж	Цаашид ОНХС-ийн хөрөнгөөс олгосон урьдчилж төлсөн зардлуудыг НББ-ийн үнэн зөв тайланд тусгаж НББ-ийн тухай хууль, бусад заавар журмын хэрэгжилтийг хангаж ажиллана. Тухайн үед хөрөнгө оруулалтын ажлын 18.4 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардлыг бүртгээгүй байсан. ЕБС-ийн биеийн тамирын зааланд бөхийн дэвжээ /3.4 сая/, хүүхдийн тоглоомын талбай /15.0 сая/ ажлуудыг 2021 онд эхлүүлээд 2022 онд хүлээж авч бүртгэлд тусгасан.

11	3.2.3. Сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв оруулж иргэдэд ил тод нээлттэй мэдээлсэн үү?	Бүрд сум ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагналтыг Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан "ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-ын 10.2-т заасны дагуу Удирдлагын мэдээллийн системд 223.9 сая төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн байна.	223.9	Зөвлөмж	Хүлээн зөвшөөрсөн	Зөвлөмж	ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагналтыг Удирдлагын мэдээллийн системд тухай бүрт үнэн зөв оруулж иргэдэд ил тод нээлттэй мэдээлж ажилласан.
12	3.2.4. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цаг тухайд нь мэдээлсэн үү?	Шилэн дансны тухай хуульд заасны дагуу 10 сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр олгосон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт 19-д тусгасан маягтаар цахим хуудсанд 4 аж ахуйн нэгж 104.5 сая төгрөгийн байршуулж гэрээний биелэлтийг хангуулж ажиллах	104.5	Албан шаардлага	Хүлээн зөвшөөрсөн	Албан шаардлага	Шилэн дансны цахим хуудсанд 4 аж ахуйн нэгжийн 104.5 сая төгрөгийн гэрээний биелэлтийн мэдээллийг нөхөж байршуулсан. Цаашид гүйцэтгэгч байгууллагуудын гэрээний биелэлтийг тогтмол шилэн дансаар тайлагнаж байх тал дээр анхаарч ажиллана.

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА

М. МӨНХБАЯР

БИЕЛЭЛТ БИЧСЭН:

САНХҮҮ АЛБАНЫ ДАРГА

Г. АНХТӨР